Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах шинжээч, Циен-Ойдов Намчинсүрэн

# 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; | | | | | | | |
| 1 | Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг шинэчлэн батлуулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо | Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” А/497 дугаар тогтоол | Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг шинэчлэн батлуулсан байна. /баримт бичиг 1/ | Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/42 дугаар тушаалаар "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын төслийг боловсруулах Ажлын хэсгийг батлуулан эхний хувилбарыг боловсруулсан. Журмын төсөлд Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газар, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан зэрэг холбогдох түвшинд хэлэлцүүлж, "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын төслийг эцэслэн яамдаас санал | 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

2 95

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авахаар гаргасан. 2025 оны 12 сарын Засгийн газрын хуралдаанд багтаан хэлэлцүүлж, батлуулахаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 2 | Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, орон тоог шинэчлэн батлуулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | ЗГ-ын 2019 оны 50 дугаар тогтоол, 2022 оны 497 дугаар тогтоол | Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, орон тоог шинэчлэн батлуулсан байна. /баримт бичиг 1/ | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т "Сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.3-т заасны дагуу ажлын албатай байх бөгөөд ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газар тогтооно." гэж заасныг үндэслэн Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, орон тоог шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Засгийн газрын хуралдааны шийдвэрээр ҮШУТСанг Ажлын албаны дарга, "Захиргаа, удирдлагын хэлтэс /6/", "Мэдээллийн сан, төслийн хяналт шинжилгээний хэлтэс/9/", " Санхүүгийн хэлтэс/6/" гэсэн бүтцийн 3 нэгж; нийт 22 орон тоотой ажиллахаар тогтоолоо.<br>Хавсралт: 1 файл | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 3 | Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо /Тоо/ | ЗГ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолын 38 дугаар хавсралт, 2007 оны 146 дугаар тогтоол | Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж, | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4 дэх хэсгийг тус тус үндэслэн "Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрэм"-ийг шинэчлэн боловсруулсан. Засгийн газрын хуралдааны журмын дагуу бүх яамд, | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | батлуулсан байна. /баримт бичиг 1/ | Үндэсний хороодоос тус тогтоолын төсөлд саналыг авч нэгтгэн, яамдын нэгдсэн товчооныг гарган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж батлуулахаар ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хавсралт: 2 файл | | |
| 3.1. Зорилт 7. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; | | | | | | | |
| 4 | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ЭЗХ-ийн сайдын дэргэдэх ШУТ-ийн салбар зөвлөл, Сансрын бодлогын зөвлөл, тэдгээрийн дүрмийг боловсруулж, батлуулсан байна. | Батлуулсан баримт бичгийн тоо /Тоо/ | БШУ-ны сайдын 2023 оны А/300, 2018 оны А/754 дүгээр тушаал | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ЭЗХ-ийн сайдын дэргэдэх ШУТ-ийн салбар зөвлөл, Сансрын бодлогын зөвлөл, тэдгээрийн дүрмийг боловсруулж, батлуулсан байна. | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн сайдын дэргэдэх яамны Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм, Сансрын бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсруулж, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны "Шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай" А/32 дугаар тушаал, "Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай" А/39 дүгээр тушаалаар тус тус батлуулсан. Хавсралт: 2 файл | 9-р сар, 10-р сар, 11-р сар | 100% |
| 3.2. Зорилт 8. Шинжлэх ухааны судалгаа, дэвшилтэт технологи, инновацыг эдийн засгийн тэргүүлэх салбаруудад нэвтрүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх замаар аж ахуйн нэгжүүдийн тогтвортой өсөлтийг дэмжих, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, шинжлэх ухааны судалгааны төслийн бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг хангах; | | | | | | | |
| 5 | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт 2025 оноос | 2025 онд хэрэгжүүлсэн шинжлэх ухаан, технологийн | Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" А/497 | Сонгон шалгаруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион | Засгийн газрын 2022 оны 497 дугаар тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эхлэн хэрэгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана. | төслийн тоо /Тоо/ | дугаар тогтоол | байгуулж, холбогдох шийдвэрийг баталгаажуулж, хэрэгжилтийг хангасан байна. /нийт 60 төсөл/ | түүнд хяналт тавих журам"-ын дагуу 2025 оноос эхлэн хэрэгжих суурь, технологийн туршилт зүгшрүүлэлтийн төсөл болон хамтарсан төслийн мэдүүлгийг ШУТС-ийн цахим системээр авч, шинжээчийн олонхийн санал дүгнэлт авсан нийт 171 төслийг шинжлэх ухааны 7 салбар чиглэлээр сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, Мэргэжлийн хорооны хурлаар хэлэлцүүлж, 2025 онд шинээр хэрэгжих нийт 60, үүний 51 нь суурь судалгааны, 9 нь технологийн туршилт зүгшрүүлэлтийн төсөл хэрэгжихээр шийдвэр гаргасан байна.<br>Хавсралт: 3 файл | 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 6 | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гаргана. | Мониторингийн тайлан, дүгнэлт шийдвэрийн тоо /тоо/ | Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” А/497 дугаар тогтоол | Төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээ дүгнэлт гарч, санхүүжилтийг шийдвэрлэн, судалгааны үр дүнг чанаржуулах, тасралтгүй үргэлжлэх зохицуулалтыг хангасан байна. /дүгнэлт тайлан 1/ | Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” А/497 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 онд ҮШУТСантай хамтран сангийн захирлын тушаал, баталсан ажлын удирдамжийн дагуу Биологи, Хими, химийн технологи, Түүх, угсаатан зүй, Хэл зохиол, Физик технологийн хүрээлэн, Газарзүй, гео-экологийн хүрээлэн, Монгол Улсын их сургууль, ШУТИС, ХААИС дээр хэрэгжиж дууссан болон үргэлжлэн хэрэгжиж буй шинжлэх ухаан, технологийн 115 төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд явцын | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | 100% |

300

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үнэлгээ дүгнэлт өгч, үр дүнг тодорхойлж, цаашид судалгааны чанар, үр дүнг дээшлүүлэх талаар зөвлөмж, чиглэл өгөв. Явцын мониторингийн үр дүнд үндэслэн дээрх төслүүдийн 2025 оны санхүүжилтийг үргэлжлүүлэн олгохоор шийдвэрлэсэн. Хавсралт: 1 файл | | |
| 7 | Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд санхүүжилт олгох ажлыг зохион байгуулна. | Санхүүжүүлсэн судалгааны үндсэн чиглэлийн тоо /Тоо/ | Засгийн газрын 2022 оны "Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх журам" 409-р тогтоол | ШУТС-тай хамтран гэрээг байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээний дагуу санхүүжилт олгогдсон байна. /гэрээ 32/ | Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,хөгжлийн сайдын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/33 дугаар тушаалаар Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн 2024 оны судалгааны үндсэн чиглэлийн тайлан үр дүнг хэлэлцэж, хүлээн авах эсэх асуудлыг шийдвэрлэх Ажлын хэсгийг батлуулж, хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус тайлан үр дүнд үндэслэн Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн саналыг авч тусгасны үндсэн дээр 2025 онд санхүүжүүлэх хүрээлэн, төвийн үндсэн чиглэлийг батлуулсан. Үндэсний шинжлэх ухаан, технологийн сантай хамтран шийдвэрийг хэрэгжүүлж, холбогдох гэрээг төрийн өмчит хүрээлэнгүүдтэй хийж, санхүүжилтийг олгосон. Хавсралт: 5 файл | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

801

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Шинжлэх ухаан, технологийн Үндэсний хороо болон салбарын харьяа байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана. | Хорооны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилтийн хувь /Хувь/ | 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө | Байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан байна. | Шинжлэх ухаан, технологийн шууд удирдлагын байгууллагууд болох ЭЗХЯ-ны харьяа эрдэм шинжилгээний 6 хүрээлэн, ШУА, Шинжлэх ухаан, технологийн сан, Шинжлэх ухааны паркийн захиргаа болон Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангахын зэрэгцээ эдгээр нэр бүхий байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, яамны холбогдох газар ТЗУГ-аар хянуулан баталгаажуулж, тухайн байгууллагуудад хүргүүлсэн. Батлагдсан төлөвлөгөөнд үндэслэн харьяа байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх тайлангийн хурлын удирдамжийн дагуу ҮШУТС-ийн захирлын тушаалаар Ажлын хэсэг гарч, тайлан, үр дүнг хүлээн авсан болно.<br>Хавсралт: 7 файл | 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | 100% |
| 9 | Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн 2024 оны тайлан, үр дүнг хэлэлцэж, 2025 оны санхүүжилтийг олгох эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. | Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн 2024 оны тайлан /27 хүрээлэн төв/ | Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн 2023 оны тайлан хэлэлцсэн байдал | Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн 2024 оны тайлан, үр дүн /27 хүрээлэн төв/-г хэлэлцэж, 2025 оны санхүүжилт/32 хүрээлэн төв/-ийг олгох эсэх асуудлыг хэлэлцэн | Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,хөгжлийн сайдын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/33 дугаар тушаалаар Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн 2024 оны судалгааны үндсэн чиглэлийн тайлан үр дүнг хэлэлцэж, хүлээн авах эсэх асуудлыг шийдвэрлэх Ажлын хэсгийг батлуулж, хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус төрийн | 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | 100% |

302

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шийдвэрлэнэ. | өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн 2024 оны тайлан, үр дүн /27 хүрээлэн төв/-г хэлэлцэж, 2025 оны санхүүжилт/32 хүрээлэн төв/-ийг олгохоор хурлын шийдвэрийг албажуулсан. Хавсралт: 3 файл | | |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Эрхэлсэн ажил чиг үүргийн хүрээнд Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжийн талаарх мэдлэг чадвараа тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн чиглэлээр сонгуульт ажил/ШУА-ийн Бага чуулганы хурал/-д оролцоно . | Эрхэлсэн ажил чиг үүргийн хүрээнд Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжийн талаарх мэдлэг чадвараа тасралтгүй хөгжүүлнэ. | 2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн: - ХАА-ны А3 сертификат - ЭЗХЯ-аас зохион байгуулсан сургалт, хурал, вебинар | Хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, салбарын хууль эрхзүйн орчныг сайжруулах Ажлын хэсэгт ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, эрхэлсэн ажил, чиг үүргийн хүрээнд оролцоно. /+ШУА-ийн Бага чуулганы хуралд/ | 2025 онд ЭЗХЯ-аас зохион байгуулагдсан болон зарим газар нэгжээс "Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах", Монгол Улсад тогтвортой дэд бүтцийн хөгжил болон ногоон санхүүжилт, "Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж", "Healthy is the new cool" сэдвээр зохион байгуулсан хурал, семинар, вебинар (нийт 16, сүүлийн хагаст 5)-т эрхэлсэн ажлын чиг үүргийн хүрээнд тухай | 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрд нь оролцсон. Гэхдээ хөдөө орон нутагт болон нийслэлд харьяа байгууллагад албан ажлаар ажиллах, хяналт мониторингийн ажилтай байх үед зохион байгуулагдсан зарим нэг сургалтад биечлэн оролцоогүй болно. /"www.erp-e.mongolia" системээр газрын даргад тухай бүрт цахимаар ажилласан төлөвийн хүсэлт илгээж, шийдвэрлүүлсэн./ | | |
| 2 | Хуульчдын мэргэжлийн сургалт болох "Хуулийн төсөл боловсруулах сургалт"-д хамрагдаж, сертификат авна. | Хуульчдын мэргэжлийн сургалт болох "Хуулийн төсөл боловсруулах сургалт"-д хамрагдаж, сертификат авна. | * | Хуульчдын мэргэжлийн сургалт болох "Хуулийн төсөл боловсруулах сургалт"-д хамрагдаж, сертификат авна. | Хуульчдын мэргэжлийн сургалт болох "Хуулийн төсөл боловсруулах сургалт"-д хамрагдаж,сертификат авсан. Хавсралт: 1 файл | 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТУ32861 6806236 9022010236

ХЯНАСАН:

Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Батболд Мөнхтөр /............................................................/ Огноо: 2025-12-10

ТАЙЛАН ГАРГАСАН:

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах шинжээч

Циен-Ойдов Намчинсүрэн /............................................................/ Огноо: 2025-12-10